



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2009 оны 6, 7 дугаар сар

Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын чиглэлээр ТХХТ-ийг Монголд байгуулах тухай семинар

УИХ-ын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) түр хорооноос тавьсан хүсэлтийн дагуу ЭЗБШӨЧ төсөл, Дэлхийн Банкны Институт, Азийн Хөгжлийн Банкны (АХБ) Институт болон УИХ-ын ТХХТ-ийн түр хороотой хамтран 7 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд Засгийн газрын ордонд ТХХТ-ийн талаар хоёр өдрийн семинар зохион байгууллаа.

Дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд хувийн хөрөнгө оруулалтыг татах чиглэлд ТХХТ-ийн олон улсын шилдэг туршлагаудаас суралцах, санал бодлоо солилцох, судлах зорилгоор төр, хувийн хэвшлийн дотоод, гадаадын зөвлөхүүд болон шийдвэр гаргагчид цугларч уг семинарт оролцов. Семинарын зорилго дараахь асуудалд чиглэгдэв. Үүнд:

- Монгол улсын эдийн засгийн өсөлтийн чиг хандлагад нийцэхүйц дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх тэргүүлэх салбар, ТХХТ-ийн төслүүдийг тодорхойлох
- Хувийн хөрөнгө оруулалтыг татах, эрсдэлийг зохистой хуваарилах замаар төслүүдийг "ашигтай" болгох нөхцөлийг бүрдүүлэх эрх зүй, зохицуулалтын болон институцийн орчинг бий болгох олон улсын туршлагаас авсан сургамжуудыг хэрэгжүүлэх
- Тээвэр, эрчим хүчний салбарт ТХХТ-ийн дэд бүтцийн төсөл хэрэгжүүлэх боломжийг тус улсад бий болгоход шаардлагатай бодлогын нэн тэргүүнд авах арга хэмжээнүүдийн талаар ярилцаж, санал солилцох

санал солилцож, үүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүй, зохицуулалтын болон институцийн нөхцөлийн талаар ярилцлаа.

УИХ-ын гишүүн бөгөөд ТХХТ-ийн түр хорооны дарга Р. Амаржаргал, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч. Хашчулуун нар Монгол Улсын Засгийн газар (МУЗГ)-ын 2008-2012 оны мөрийн хөтөлбөрийн нэг хэсэг болох ТХХТ-ийг хэрэгжүүлэхэд МУЗГ чин эрмэлзэлтэй буйг дурьдаад ТХХТ-ийг нэвтрүүлэхэд нээлттэй, ил тод, эрх тэгш, хариуцлагатай байдлыг хангахын чухлыг цохон тэмдэглэв.



Pinsent Masons LLP компанийн Олон улсын эрх зүйн зөвлөх Антони Смит, АНУ/ЭЗБШӨЧ төслийн ТХХТ-ийн зөвлөх Патрисисо Мансила, Монголын Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирал Х.Ганбаатар нар "Дэд бүтцийн салбар дахь төр-хувийн хэвшлийн түншлэл: Арга зам ба хандлага" сэдэвт хэлэлцүүлгийг удирдан явууллаа. Энэхүү хэлэлцүүлэг, бүлгийн хэлэлцүүлгээр таамаглаж болохуйц орчинд эрсдэлийг зохистой хуваарилж, ТХХТ-ийн санал болгож буй нөхцөл шударга байх явдлыг баталгаажуулах замаар өмнө нь гарч байсан, тухайлбал ДЦС5-ын тендер зэрэг алдаанаасаа сургамж авч болно хэмээн дүгнэлээ. Зөвлөх Мансила "ТХХТ-ийн дэлхийн нийтийн чиг хандлага" сэдэвт презентаци тавьж, ТХХТ-ийн явцыг Монгол улсад түргэвчлэх чиглэлд хэрэгжүүлж болох олон улсын туршлага, янз бүрийн арга зам, хандлагуудын талаар танилцуулав.

Улмаар ТХХТ-ийн эрх зүй, зохицуулалтын болон институцийн хүрээ, Их Британи, БНСУ-ын туршлагыг ярилцсанаас гадна ТХХТ-ийн эрх зүйг бий болгоход анхаарвал зохих гол асуудлуудыг онцолж, Монголын хувьд дараагийн хийх алхам бол ТХХТ-ийн бодлогын хүрээг тодорхойлох явдал гэдгийг тэмдэглэлээ. Сүүлчийн хэлэлцүүлгээр дэд бүтцийн санхүүжилтийн эх үүсвэр, чиг хандлагын талаар хэлэлцэж, Ази болон дэлхийн бусад орны туршлагын талаар санал солилцсон. Дэд бүтцийн Морган Стенли сангийн гүйцэтгэх



Семинарын эхний өдрийн хөтөлбөр "Дэд бүтцийн хөгжил ба санхүүжилт" гэсэн асуудалд чиглэгдэж, Монгол улсын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн боломжит түншлэлийн хоорондын уялдаа холбоо, дэд бүтцийн санхүүжилтэд хувийн хөрөнгө оруулалтыг татах бусад улс орны туршлагын талаар

захирал Жоу Чанг ТХХТ-ийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд ил тод байдлыг эрхэмлэж, эрсдэлийг зохистойгоор байршуулахын чухлыг тэмдэглээд, аливаа улс оронд хөрөнгө оруулагчдад таатай нөхцөлийг бүрдүүлэхийн ач холбогдлыг онцоллоо. Үүнээс гадна хэрэгжүүлэх төслүүдийн эрэмбэ дарааллыг тогтоож, төслүүдийг нэг удаагийн түр авах арга хэмжээ бус харин цогц арга хэмжээ гэсэн үүднээс хандахыг зөвлөв. Ингэснээр Монгол улсад хөрөнгө оруулалтын найдвартай, баталгаатай нөхцөл бүрдэх болно.

Хоёр дахь өдрийн семинар "Монгол улсад дэд бүтцийн хөрөнгө оруулалтад ТХХТ-ийг дэмжих орчинг бүрдүүлэх бодлого" сэдвийн дор явагдаж Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нар семинарыг нээж үг хэлэв. Төмөр зам, авто зам, эрчим хүчний хуучирсан, үр ашигтай муутай дэд бүтцийг сайжруулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг хоёр сайд цохон тэмдэглээд, эдгээр салбарын хөрөнгө оруулалт нь Монголын уул уурхайн салбарыг дэмжих болно гэдгийг тэд онцоллоо. Семинарт оролцогчид болон зөвлөхүүд Монгол улсад нэн тэргүүнд хэрэгжүүлэх боломжтой тодорхой төслүүд, үүний дотор ДЦС#5 тендерийг дахин зарлах, Замын -Үүдэд логистик парк болон авто замаас төмөр замд шилжүүлэн ачих байгууламжийг байгуулах талаар хэлэлцэв.

Семинараас гаргасан гол зөвлөмжүүд. Үүнд:

- Концессийн тухай хуулийн төсөл болон ТХХТ-ийн бодлогын хүрээний талаар зөвшилцөлд хүрэх
- Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (ҮХШХ)-той хамтран ТХХТ-ийн боломжит төслүүдийн багцыг гаргаж, хэрэгжүүлэх эрэмбэ дарааллыг тогтоох, ТХХТ-ийн асуудалд нэг удаагийн түр авах арга хэмжээ мэтээр хандахгүй байх
- ТХХТ-ийн багцыг хэрэгжүүлж, үйл ажиллагааг нь удирдан зохицуулах үүрэг бүхий ТХХТ-ийн нэгжийн гол чиг үүрэг, эрх, үүргийн талаар зөвшилцөх
- Хөрөнгө оруулалтыг татах, тогтоон барих үүднээс талуудын дунд эрсдэлийг зохистой хуваарилах, таамаглаж болохуйц үйл ажиллагааны орчинг бий болгохын ач холбогдол.

Семинарын төгсгөлд Засгийн газраас Концессийн тухай хуулийн төслийг УИХ-ын намрын чуулганаар эхний ээлжинд хэлэлцүүлэхээр өргөн барьсан тухай оролцогчдоод мэдээлсэн юм. ЭЗБШӨЧ төсөл эрсдэлийг зохих ёсоор хуваарилж байршуулах замаар хувийн хөрөнгө оруулалтыг татах боломж бүрдүүлэх үүднээс одоогийн хуулийн төслийг олон улсын шилдэг туршлагаудад ойртуулахад шаардагдах гол өөрчлөлтүүдийн талаар зөвшилцөлд хүрэхэд туслалцаа үзүүлэх болно.

Ипотекийн зах зээлийг хөгжүүлэх талаар дугуй ширээний ярилцлага болов

Их тэнгэр цогцолборт 6 дугаар сарын 20-ны өдөр болсон Ипотекийн зах зээлийн асуудлаархи дугуй ширээний ярилцлагыг Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Монголын Ипотекийн корпораци (МИК), ЭЗБШӨЧ төслөөс хамтран зохион байгуулж, ивээн тэтгэлээ. Уг ярилцлагад ОУСК-ийн орон сууцны санхүүжилтийн зөвлөхүүд, УИХ-ын гишүүд, МИК-ийн ТУЗ-ийн гишүүд, арилжааны банкууд, Монголбанк (МБ), ЭЗБШӨЧ төслийн төлөөлөгчид оролцов.

ЭЗБШӨЧ төсөл Монгол улсын иргэдийг боломжийн орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх механизм болох ипотекийн урьдчилгаа төлбөрийн шууд татаасыг хэрэглэх тухай презентаци тавьж, банкны тогтолцоонд хөрвөх чадвартай

хэрэгслийг нэвтрүүлэх талаар ярилцлага өрнүүлэв. МИК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бөгөөд Худалдаа, хөгжлийн банкны ерөнхийлөгч Рандольф Коппа Монгол улс дахь орон сууцны санхүүжилтийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар презентаци тавьж, МИК-ийн үйл ажиллагааны хөгжлийн цаашдын төлөв байдлын талаар онцолсон. МИК-ийн гүйцэтгэх захирал Н. Энхбаяр МИК-ийн хэтийн зорилго, зорилтуудыг танилцуулав. ОУСК-ийн зөвлөхүүдээс ипотекийн санхүүжилтийн байгууллагуудыг үүсгэн байгуулсан олон улсын туршлага, хөгжиж буй орнуудын ипотекийн зах зээлийн хөгжилд тулгарч буй хүндрэл бэрхшээл, боломж бололцооны талаар мэдээлэл өглөө.



Дугуй ширээний ярилцлага нь Монголбанк, МИК, арилжааны банкууд, УИХ-ын гишүүд, олон улсын санхүүгийн байгууллагуудын дунд ипотекийн зах зээлийн өнөөгийн байдал, орон сууцны санхүүжилтэд хамрагдан орон сууц худалдан авах Монгол улсын иргэдийн боломж бололцоог нэмэгдүүлэх арга замын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх боломж олгосон юм.



УИХ-ын гишүүд, Хууль зүйн байнгын хорооны дарга Н. Энхбаяр нарын зүгээс Ипотекийн хуулийн төслийн хянаж,

УИХ-ын хаврын чуулган хаахаас өмнө хэлэлцүүлж батлуулна гэдэгт найдаж байгаагаа илэрхийллээ.

МКЗХТ нийт гишүүдийн болон ТУЗ-ийн анхны хурлаа хийлээ

Монголын Компанийн засаглалын хөгжлийн төв (МКЗХТ) нийт гишүүдийн хурлаа 2009 оны 6 дугаар сарын 2-ны Мягмар гарагт Хаан банкны байранд зарлан хуралдууллаа. Тус төвийн 22 гишүүн (32-оос) хуралд оролцож, ирцээ бүрдүүлэв. Гишүүд ТУЗ-ийн 9 гишүүнийг сонгож, МКЗХТ-ийн дүрэм, 2009-2010 оны бизнесийн төлөвлөгөөгөө батлав.



МКЗХТ-ийн гишүүнчлэл нь мэргэжлийн хүмүүс, тус төвөөс энэ оны 2, 3 дугаар сард зохион байгуулсан Сургагч багш нарын курсийг дүүргэсэн багш нар болон Захирлуудад зориулсан сургалтын курсийг дүүргэсэн гүйцэтгэх захирлуудаас бүрдэж байна. Гишүүн байгууллагуудад Хаан банк, Хас банк, Голомт банк, Туул Сонгино Усны нөөц хувьцаат компани орж байгаа аж.

МКЗХТ-ийн ТУЗ-ийн анхны хурлыг 6 дугаар сарын 5-ны өдөр хийв. ТУЗ-өөс тус төвийн гүйцэтгэх захирлаар Ж.Үнэнбатыг, нарийн бичгийн даргаар Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн зааварлагч багш Т. Цэнд-Аюушийг тус тус нэг жилийн хугацаагаар томиллоо.

МХЕГ-ын улсын байцаагчид олон нийттэй харилцах тухай сургалт семинарт оролцлоо

ЭЗБШӨЧ төсөл Хэвлэлийн хүрээлэнтэй хамтарч Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-ын улсын байцаагчдад зориулан "Олон нийттэй харилцах харилцаа холбоо" сэдэвт хоёр өдрийн сургалт семинарыг 6 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгууллаа.

МХЕГ-ын үүрэг роль, чиг үүргийн талаар олон нийтэд ойлгуулах, олон нийттэй харилцах ажлыг хэрхэн амжилттай зохион байгуулах талаар ерөнхий ойлголт өгөх зорилго бүхий уг семинарт Улаанбаатар хот, Дорноговь аймгийн мэргэжлийн хяналтын албадын 15 улсын байцаагч оролцов.



Хэвлэлийн хүрээлэнгийн олон нийттэй харилцах албаны мэргэжилтнүүд уг сургалтын өмнөхөн МХЕГ-аас зохион байгуулж буй олон нийттэй харилцах ажлын өнөөгийн байдал, чанарт үнэлгээ хийсэн юм. Энэхүү үнэлгээний үр дүнд тулгуурлан Хэвлэлийн хүрээлэнгээс тус агентлагийн олон нийттэй харилцах ажлын тусгайлсан хэрэгцээг хангахуйц сургалтын материалыг бэлтгэсэн байна. Уг үнэлгээ нь тус агентлагийн олон нийттэй харилцах ажлыг сайжруулахад тус дөхөм болно.

Сургалтын хөтөлбөрийн дагуу тус байгууллагын хэвлэл мэдээллийн ажилтны хийж гүйцэтгэдэг ажлаас гадна олон нийттэй хэрхэн үр дүнтэй харилцаж, харилцаагаа өргөжүүлэх боломж бүрдүүлэхэд нь улсын байцаагчдад зохих ойлголт өгөх зорилгоор "Олон нийттэй харилцах харилцаа гэж юу вэ, энэ нь зар сурталчилгаа, маркетингээс юугаараа ялгаатай вэ", "Хэвлэлийн тоймыг хэрхэн сайн бичих вэ", "Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийттэй хэрхэн харилцах вэ", "Хэвлэл мэдээллийн байгууллагатай хэрхэн харилцаа тогтоож, амжилттай хамтарч ажиллах вэ" зэрэг сэдвээр презентаци тавилаа.

Сургалт семинарын дараа Хэвлэлийн хүрээлэнгээс уг сургалтын үр дүнд гарсан өөрчлөлт, үр нөлөөг үнэлэх зорилгоор тус агентлагийн олон нийттэй харилцах ажлын түвшин, чанарт үнэлгээ хийхээр төлөвлөж байна. Дээрх сургалт семинарыг ЭЗБШӨЧ төсөл, МХЕГ хооронд байгуулсан ХОСБ-т багтсан тус агентлагийн ажлын үр дүн, үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын хүрээнд зохион байгуулсан юм.

Монгол улсын өрсөлдөх чадварт Компанийн засаглалын үзүүлэх ач холбогдлын талаар сэтгүүлчдэд зориулан сургалт зохион байгууллаа

Хэвлэлийн хүрээлэн, Монголын Компанийн засаглалын хөгжлийн төв (МКЗХТ), ЭЗБШӨЧ төсөл хамтран 6 дугаар сарын 30-ны өдөр компанийн засаглалын талаар сэтгүүлчдэд зориулан сургалт зохион байгуулж, өдөр тутмын болон долоо хоногийн сонины 10 сэтгүүлч мөн 9 телевиз, 2 радио, 1 сэтгүүл, 1 онлайн сонины нийт 28 сэтгүүлч оролцлоо.



АНУ-ын ОУХА-ын ЭЗБШӨЧ төслийн Компанийн засаглалын зөвлөх доктор Енер, МКЗХТ-ийн гүйцэтгэх захирал Ж.Үнэнбат, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн Д.Дүгэржав, АНУ-ын ОУХА-ын ЭЗБШӨЧ төслийн санхүүгийн мэргэжилтэн Д.Хангал нар Монгол улсын өрсөлдөх чадварт компанийн засаглалын үзүүлэх үр нөлөө, ач холбогдлын талаар презентаци тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэн Хэвлэлийн хүрээлэнгийн багш нартай хамтран кэйс судалгааны дүн шинжилгээ хийв. Сургалтын хөтөлбөр нь компанийн засаглалын тулгуур зарчмууд, үүний дотор ил тод, хариуцлагатай байдал, үүрэг хариуцлага, шударга байдлын талаар сэтгүүлчдэд ойлголт өгөх, түүнчлэн МКЗХТ-ийн талаархи олон нийтийн ойлголт, сэтгүүлчдийн мэдээллийг дээшлүүлэхэд зориулагджээ.

Сургалтын явцад сэтгүүлчид бүлгүүдэд хуваагдан *'Монголын компаниудын хувьд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг шинээр татаж, өсөлтөө нэмэгдүүлж, ажлын байр шинээр бий болгоход шийдвэрлэх ач холбогдолтой ямар асуудлууд байна гэж та үзэж байна?'; 'Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд ямар гол хүндрэлтэй асуудлуудтай тулгарч байна вэ?'; 'Монгол дахь гэр бүлийн эзэмшлийн компаниуд, жижиг үйлдвэрүүд ямар гол хүндрэлтэй асуудлуудтай тулгарч байна вэ?'* зэрэг асуултанд хариулт бэлтгэж санал бодлоо солилцов.

Түүнчлэн сэтгүүлчид компанийн засаглалын зарчмууд, үүний дотор *"Монголын тэргүүлэх компаниудын ил тод байдал, мэдээллийн нээлттэй байдлын харьцуулсан судалгаа", "Монгол улс дахь гэр бүлийн эзэмшлийн компанийн удирдах зөвлөл", "Энэтхэгийн Сатям корпорацид гарсан компанийн луйвар", "Компанийн гүйцэтгэх захирлуудын ил тод, хариуцлагатай байдал, үүрэг хариуцлага"* зэрэг презентацийг хэлэлцлээ. Сургалт семинарын төгсгөлд 2008 оны 10 дугаар сард хийсэн Монголын компанийн засаглалын орчны үнэлгээний ач холбогдлыг онцлон тэмдэглэж, компанийн засаглалын хууль эрх зүй, зохицуулалтын хүрээний талаар санал бодлоо солилцон, харилцан ярилцсан байна. Уг ярилцлагад Д. Дүгэржав, Ж. Үнэнбат, доктор Енер, ОУСК-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга Дэвид Лоренс нар оролцов.

Монгол улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд тус улсын компаниуд мэдээллээ олон нийтэд ил тод болгох ёстой гэдэгт сэтгүүлчид санал нэгтэй байв. Дээрх сургалт компанийн засаглалын талаар мэдээлэл өгөх, компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, мэдээлэх тайлагнах ур чадварыг сайжруулахад ач холбогдолтой боллоо.

МКЗХТ сургагч багш нарыг бэлтгэх хоёр дахь курс сургалт зохион байгуулав

2009 оны 6 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд болсон Компанийн засаглалын сургагч багш нарыг бэлтгэх курс сургалтад их дээд сургууль, Төрийн өмчийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, арилжааны банкууд, төрийн болон хувийн хэвшлийн томоохон компаниудын сургалтын 20 мэргэжилтэн оролцов. Зааварлагч багш доктор Енер, Ж.Үнэнбат нар 14 модуль бүхий курс сургалтын дөрвөн өдрийн турш явууллаа. Модуль тус бүрт лекц, кэйс жишээ, хэлэлцүүлгийн цаг, хэлэлцүүлгийн завсарлага багтсан байв.



Сургалтын хэлэлцүүлгийг Монгол улс дахь компанийн засаглалын асуудлууд, боломжит арга замын талаар оролцогчдын дунд нээлттэй, харилцан ярилцах хэлбэрээр явуулсан юм. Компанийн засаглалын олон улсын шилдэг туршлагаудын талаар доктор Енер презентаци тавьж, оролцогчид эдгээрийг тус улсад хэрхэн хэрэглэж нэвтрүүлэх боломжийн талаар ярилцлаа. Сургалтын төгсгөлд оролцогчдын таван бүлэгт хувааж, бүлэг тус бүр тус тусын салбар дахь компанийн засаглалын хүндрэлтэй асуудлууд, тэдгээрийн шийдлийн талаар презентаци тавьснаар өндөрлөсөн юм.

Дөрвөн өдрийн курс сургалтыг төгссөн оролцогчид сертификат гардаж, МКЗХТ-ийн сургалтын чадавхийг бэхжүүлээ.



Монгол улсын иргэдэд үйлчлэх МХЕГ-ын үүрэг роль, чиг үүргийн талаар сэтгүүлчдэд зориулан сургалт хийлээ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын олон нийттэй харилцах ажлыг дээшлүүлэхэд зориулсан сургалтын дараа МХЕГ, Хэвлэлийн хүрээлэн, ЭЗБШӨЧ төслөөс хамтран тус агентлагийн үүрэг роль, хариуцлагын талаархи олон нийтийн ойлголт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах үүднээс түүний зорилго, чиг үүрэг,



хийж буй ажлын талаар сэтгүүлчдэд зориулан нэг өдрийн сургалтыг энэ 7 дугаар сарын 19-ний өдөр зохион байгууллаа.

Уг сургалтад өдөр тутам, долоо хоногийн 10 сонин, 6 телевиз, 3 радио, МОНЦАМЭ агентлагийн нийт 23 сэтгүүлч оролцов. Сургалтын хөтөлбөрт Монгол улсын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдалд хамаарах гол асуудлууд, тухайлбал, байгаль орчны хяналт, модны хулгай, экспорт, импортын бараа бүтээгдэхүүний болон барилгын салбарын хяналт



шалгалт, мэргэжлийн хяналтын эрх зүйн орчин, улсын байцаагчдын эрх, үүрэгтэй холбоотой сэдвүүд хамрагдсан юм.

Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын албаны улсын ахлах байцаагч Д.Цэрэндашийн модны хулгайн байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө, хор хохиrol, хяналт шалгалтад учирч буй хүндрэлүүдийн талаар тавьсан "Байгаль орчны хяналт шалгалт: Модны хулгайтай хэрхэн тэмцэж байгаа тухай" презентацийг сэтгүүлчид гойд сонирхлоо. Түүнчлэн Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын албаны улсын ахлах байцаагч С. Баяраагийн тавьсан "Барилгын салбарт хийсэн ажлын байрны аттестачлалын шалгалтын дүн" –гийн талаар тавьсан презентацид ялангуяа барилгын салбарт ажиллаж буй иргэдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалахад мөрддөг хяналт шалгалтын дүрэм журам, стандартуудын талаархи олон

нийтийн ойлголтыг сайжруулах зайлшгүй шаардлага байгааг онцолсон юм. Тэрээр мэдээлэхдээ 2008 оныг 2007 онтой харьцуулахад барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой осол 98.4 хувиар нэмэгдсэн бөгөөд нийт 61 осол гарч 149 хүн өртсөний 63 нь амь насаа алдсан гэлээ. С. Баяраа барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартыг мөрдүүлэх, ажил хөдөлмөртэй холбоотой осол гэмтлийг бууруулахад хяналт шалгалт онцгой ач холбогдолтой болохыг онцоллоо.

Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга Г. Нанзад "Гадаад худалдаанд тавьж буй мэргэжлийн хяналт шалгалт", МХЕГ-ын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Алтанцоож "Мэргэжлийн хяналтын эрх зүйн орчин: Улсын байцаагчдын эрх, үүрэг" сэдэвт презентаци тавьж, мэргэжлийн хяналтын эрх зүйн орчин, улсын байцаагчдын эрх, үүргийн талаар сэтгүүлчдэд тайлбарлав.

Түүнчлэн уг сургалтын үеэр МХЕГ-аас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй харилцахад тулгарч буй бэрхшээл, хэрэгцээ шаардлага, боломжийн талаар сэтгүүлчдэд зохих мэдээлэл өглөө. МХЕГ-ын хувьд тус агентлагийн үүрэг хариуцлагыг хэвлэл мэдээллийнхэнд илүү сайн ойлгуулахын тулд үр бүтээлтэй хамтран ажиллаж, энэ нь эргээд байгууллагын талаархи олон нийтийн ойлголтыг сайжруулж, Монгол улсад амьдарч, ажиллаж буй иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хамгаалах хэрэгсэл болох хяналт шалгалтын стандартыг мөрдүүлэхэд тус дэм болно гэдэгт найдаж буйгаа илэрхийлсэн юм.

МКЗХТ компанийн нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалт зохион байгууллаа.

МКЗХТ-ийн гүйцэтгэх захирал Ж. Үнэнбатын удирдлага дор ЭЗБШӨЧ төслийн техникийн туслалцаатайгаар 7 дугаар сарын 2-ны өдөр компаниудын нарийн бичгийн дарга нарт зориулсан анхны сургалтыг зохион байгуулав. Нэг өдрийн энэхүү сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлж, мөрдүүлэхэд компанийн нарийн бичгийн дарга нарын гүйцэтгэх үүрэг ролийг тэдэнд ойлгуулж, тэдний мэдлэг чадвар, туршлагыг хөхиүлэн дэмжихэд чиглүүлсэн юм. Энэ сургалт нь МКЗХТ-ийн орлого бий болгох анхны үйл ажиллагаа байсан бөгөөд тус төвийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад зохих хувь нэмэр орууллаа.

Сургалтад Монос групп, Худалдаа, хөгжлийн банк, Мобиком корпораци, Энержи Ресурс ХХК зэрэг компаниуд, тэдгээрийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар оролцов. Сургалтын хөтөлбөрт компанийн засаглалын зарчмуудыг хэрхэн хянаж, мөрдүүлэх талаар нарийн бичгийн дарга нарт илүү сайн ойлголт өгч, тэдний чадавхийг сайжруулах чиглэлд тусгайлан боловсруулсан сэдвүүд орсон байв.

Сургалт явуулсан зааварлагч багш нар МКЗХТ-ийн сургагч багш нарын бэлтгэх курс сургалтыг дүүргэж гэрчилгээ авсан багш нар байлаа. Сургалтад оролцогчид уг сургалтыг үр өгөөжтэй болсныг онцолж, өөрсдийн компани, ТУЗ-дөө компанийн засаглалыг зарчмуудыг нэвтрүүлж, мөрдүүлэх чиглэлд ажиллах болно гэдгээ илэрхийлсэн юм.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.